

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# **АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

***/АЙМАГ БАЙГУУЛАГДСАНЫ 80 ЖИЛИЙН ОЙН АРГА  
ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН/***

**2018 он**

## Агуулга

1. Аудитын нэр
2. Аудитын код
3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх
4. Аудитын зорилт
5. Аудитад хамрах хүрээ
6. Аудитын арга
7. Эрсдлийн үнэлгээ
8. Шалгуур үзүүлэлт
9. Аудит хийх багийн үнэлгээ, хугацаа
10. Аудитын тайлан

Хавсралт -Арга зүй  
-Асуудлын шинжилгээ  
-Эрсдлийн үнэлгээ  
-Хөтөлбөр

# Булган аймаг дахь Төрийн аудитын газар

---

БАТЛАВ.

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Д.АНХБАЯР

## АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2018.09.10.

Булган

### 1. Аудитын нэр:

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний ажлын хэрэгжилтийн үр дүн.

### 2. Аудитын код:

БуТАГ-/2018/-ГА-02

### 3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймгийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

### 4. Аудитын зорилт:

Аудитын зорилт нь аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний ажлын хэрэгжилтийн үр дүн, 80 жилийн ойн санхүүгийн эх үүсвэр хандивын бүрдүүлэлт, зарцуулалт, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгийн зарцуулалт, ойн арга хэмжээний хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд тавих дотоодын хяналтыг хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгч шаардлагатай бол санал боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд оршино.

- Аймгийн 80 жилийн бүтээлч ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, ажлын тайлан
- 80 жилийн ойн арга хэмжээний орлого, хандивын бүрдүүлэлт, үр дүн,
- Хөрөнгө оруулалт, бүтээн байгууллалтын зарцуулалт,
- Хандив зээл тусламжийн зарцуулалт, үр дүн,
- Баяр наадмын үйл ажиллагааны зарцуулалт,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон замын сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн,
- Байгууллага, иргэд, орон нутгийн оролцоо ажлын үр дүн,
- Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдал,
- Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт,

### **5.Аудитын хамрах хүрээ:**

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний ажлын хэрэгжилт, хандив зээл тусламжийн бүрдүүлэлт, зарцуулалт, бүтээн байгууллалт төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, аймгийн ЗДТГ, Х өрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүү төрийн сангийн хэлтэс, ГХБХБГ, Булган сумын ЗДТГ болон ажлын хэсгүүдийн ажлын гүйцэтгэл санхүүгийн тайлан тооцоо, хяналт үр дүнг хамруулна.

### **6.Аудитын арга**

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллага ажлын хэсгийн ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

### **7. Эрсдлийн үнэлгээ**

Булган аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээний хэрэгжилт, хандив тусламжийн бүрдүүлэлт, зарцуулалт, бүтээн байгууллалт төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг “Дунд” гэж үзлээ.

### **8.Шалгуур үзүүлэлт**

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам
- Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол,
- Засаг даргын захирамжийн хэрэгжилт,
- Гэрээний биелэлтийг тооцох
- Холбогдох бусад хууль, тогтоомж

### **9. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Аймгийн төрийн аудитын газрын даргын удирдамжаар аймгийн Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, менежер Ж.Энхцоодол хяналт тавьж ахлах аудитор Г.Ганбаатар, аудитор П.Мөнхтуяа нар 2018 оны 09 дугаар сарын 10-наас эхлэн ажлын 40 хоногт багтаан удирдамжийн дагуу явуулна.

### **10.Аудитын тайлан**

Аудитын тайлан нь энгийн, тодорхой, хоорондийн уялдаа холбоотой байх бөгөөд ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, аймгийн удирдлагуудын санал болон хавсралт судалгаа тооцоо, тайлбаруудаас бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч аудитын удирдагчид танилцуулан баталгаажуулна.

ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Г.ГАНБААТАР